



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.mohs.mn

2022.02.25 № 6 / 823

танай -ны № -т

Г АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ГАЗАР, ТӨРӨЛЖСӨН
МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ
МЭРГЭЖЛИЙН ТӨВ, АМАРЖИХ
ГАЗРЫН ДАРГА, ЗАХИРАЛ НАРТ

Г Аянд нэгдэх тухай

Жендерийн үндэсний хороо нь жендер, жендерийн хэвшмэл ойлголт, жендерт суурилсан хүчирхийллийн талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулагддаг олон улсын аяныг өөрийн орны онцлогт нийцүүлэн жил бүр олон нийтийг хамруулан тодорхой үйл ажиллагаа санаачлан, дэмжин ажилладаг.

Энэ хүрээнд Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаарх ойлголт, мэдлэгийг олон нийтэд хүргэх, эрэгтэй, эмэгтэйчүүдэд тулгарч буй жендерийн асуудлыг мэдээлэх, олон нийтийн дуу хоолойг сонсох, асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлох зорилгоор “ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЭ” аяныг 2022 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс 4 дүгээр сарын 01-ний өдрийн хооронд зохион байгуулахаар төлөвлөөд байна.

Эрүүл мэндийн салбар тус аянд нэгдэж, жендерт суурилсан хүчирхийллийг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэхэд та бүхний идэвхтэй оролцоо, дэмжлэг нэн чухал юм.

“Харилцан хүндэтгэе” аянд нэгдэн Жендерийн үндэсний хорооноос баталсан удирдамж, хөтөлбөр, логог ашиглан, иргэд, олон нийтэд илгээх мэдээллүүдийг түгээж, ухуулга нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж идэвхтэй оролцно уу.

Үйл ажиллагааны удирдамж, хөтөлбөрийг хавсаргав.

Батлагдсан логог Жендерийн үндэсний хороо болон Эрүүл мэндийн яамны вэб, пэйж хуудаснаас татан авч болно.

НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГА

Д.БАЯРБОЛД

1118270972 9087443

144112062